

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ НИСЛЭГ-ТЕХНИКИЙН  
ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА БОЛОН ИРГЭНИЙ  
НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ ХООРОНД ХАРИЛЦАН  
ОЙЛГОЛЦОХ МЕМОРАНДУМ.**

---

**2005 оны 8-р сарын 22**

**Улаанбаатар хот**

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42.4, 42.6, Зам, Тээвэр, Аялал жуулчлалын Сайдын 2005 оны 3-р сарын 24-ны өдрийн 51 тоот тушаалаар батлагдсан “ Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 2.3, 2.4, 2.5, 2.6 заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохицуулахаар нэг талаас Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба ( НТОЗШША )-ны дарга **С.Хүрэлбаатар**, нөгөө талаас Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба ( НААХЗА )-ны дарга **Ц.Бат** бид энэхүү меморандумыг байгуулав.

**Нэг. Зорилго.**

Энэхүү меморандумын зорилго нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, иргэдээс агаарын тээврээр аюулгүй үйлчлүүлэх итгэлийг нэмэгдүүлэхэд оршино.

**Хоёр. Зарчим.**

1. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба нь эрх зүйн баримт бичгүүдээр олгогдсон тус тусын биеэ даасан эрх болон үүргүүдийг хүндэтгэн дараах зарчмуудад үндэслэн ажлын бүтээлч харилцааг тогтоож ажиллана.

- Хамтын ажиллагаа
- Шударга хандлага
- Харилцан итгэлцэл
- Харилцан хүндэтгэл
- Ил тод байдал
- Мэргэшлийн өндөр чадвар

2. НТОЗШША болон НААХЗА -ын хооронд үүсэж болзошгүй аливаа маргаантай асуудлыг нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын явцыг супруулахгүйгээр зохицуулж цаашдаа тус тусдаа болон хамтран доорх байдлаар ажиллахаар тохиролцов.

- Нислэгийн аюулгүй ажиллагааны эрх ашгийг дээдлэх үүднээс иргэний нисэхийн системийг сайжруулах, боловсронгуй болгох

шаардлагатайг хүлээн зөвшөөрч үүний төлөө бүх боломжоо дайчлан ажиллах;

- НТОЗШША-ны бие даасан тусгаар байдал, буруутан эрэхгүй байх зарчим, осол, зөрчлийн шинжээчийн хийсэн дүгнэлт, өгсөн зөвлөмжийг хүндэтгэх, НААХЗА-ын аюулгүй ажиллагааны тохируулагчийн тусгаар байдал, үйл ажиллагааг дэмжих;
- Иргэний нисэхийн системд эзлэх алба тус бүрийн бие даасан үйл ажиллагаа, бие биеийнхээ нэр хүндийг хамгаалах явдлыг дэмжих;
- Бие биеийнхээ үйл ажиллагаа, үйл ажиллагаанаас аюулгүй байдалд үзүүлж байгаа үр дүнг харилцан суралцах;
- Аливаа алдаа дутагдлыг харилцан ойлголцож залруулах арга замыг тогтмол хайх;
- Алба хоорондын стратегийн зөвшилцлийг дэмжих.

### **Гурав. Аюулгүй ажиллагааны асуудлаар мэдээлэх.**

1. ИНЕГ-ын НААХЗА-ны ажилтан ИНД-12, ИНЕГ-ын даргын 2004 оны 100 тоот тушаалын дагуу нислэг-техникийн осол, зөрчлийн талаар мэдээллийг хүлээн авч, дамжуулна. Мөн НТОЗШША нь өөрийн шугмаар мэдээллийг хүлээн авах ажлыг "Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм"-ээр зохион байгуулна.
  - Яаралтай мэдээлэх шаардлагатай асуудлыг НААХЗА-ын ажилтан НТОЗШША-ны шинжээч нарт аль болох түргэн хугацаанд 98-2026, 98-2096, 98-2099, 98-2097, 99114054 дугаарын утсаар мэдээлэх;
  - НТОЗШША-ны ажилтан 98-3333, 98-2002, 98-2044, 98-2016, 98-2078, 98-2032 дугаарын утсаар ИНЕГ-ын Тэргүүн дэд дарга, хэлтсийн дарга, байцаагч нар буюу ажилтанд мэдэгдэнэ.
2. НТОЗШШ Алба нь мэдээллийг хүлээн аваад осол, ноцтой зөрчил, зөрчлийн аль нь болохыг эхний ээлжинд тогтооно.
3. НТОЗШШ Алба нь тухайн мэдээллийн дагуу шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулах эсэхээ ИНЕГ-т аль болох түргэн хугацаанд мэдээлнэ.

### **Дөрөв. Шинжлэн шалгах чиглэлээр хамтран ажиллах.**

1. Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42.4, 42.6 заалтууд, Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Сайдын 2005 оны 3-р сарын 24-ны өдрийн 51 тоот тушаалаар батлагдсан "Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм" - ийн дагуу нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд талууд хамтран оролцож болно.
2. Хамтарсан үйл ажиллагааг явуулахдаа олон улсад тогтсон хэм хэмжээ, талуудын зорилго, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тэдний хоорондын ялгаа болох НТОЗШША-ын бие даасан тусгаар байдал, асуудалд буруутан эрэхгүй байх зарчим, НААХЗА-ын аюулгүй ажиллагааны тохируулагчийн тусгаар байдлыг хүндэтгэн шинжлэн шалгах ажлыг зохион байгуулалттай хийж гүйцэтгэнэ.

3. Хоёр тал нэг талын явуулж байгаа шинжлэн шалгах ажиллагаа, эсхүл бусад талуудын үйл ажиллагаанд саад болохгүй байх бодит бололцоог олгох тал дээр хамтран ажиллана.
4. Хэрэв аль нэг тал нь шинжлэн шалгалт өөрсдийнх ажил үүрэгт саад болж байна гэж үзвэл нөгөө талд асуудал тавьж болно.
5. Шинжлэн шалгах хамтын ажиллагаа нь тал нэг бүрийн нууцлалын итгэлцэл, хууль ёсны үүрэгт захирагдах ёстойг хүлээн зөвшөөрнө.
6. ИНЕГ нь НТОЗШША-ны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга барил, горим, шийдвэрт хяналт тавигч биш гэдгийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв НТОЗШША-аас осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны хүрээг өргөжүүлэн ИНЕГ-ын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга барил, горим шийдвэрт шинжлэн шалгах ажиллагаа явуулахаар бол шалгалт хийхийн өмнө хамрах хүрээний талаарх тодорхой мэдээллийг ИНЕГ-ын Тэргүүн дэд даргад мэдэгдсэн байна.

#### **Тав. Шинжлэн шалгах явцад мэдээлэл бүрдүүлэх.**

1. НААХЗА нь НТОЗШША-ны шинжлэн шалгаж байгаа асуудалд шаардлагатай баримт бичиг болон бусад нотолгоог бүрдүүлэх буюу мэрэгжилтний туслалцаа үзүүлнэ. НТОЗШША -ны шинжээч нар нь Иргэний нисэхийн тухай хуулийн 43.3.3 зүйлийн дагуу шаардлагатай мэдээлэлийг шаардан гаргуулж болно.
2. НААХЗА нь асуудалд хамтран ажиллах эрмэлзэлийн дагуу НТОЗШША-ны хүссэн мэдээллийг аль болох шуурхай гаргаж өгөхийг хичээх ба энэ хугацаа нь ажлын 5 өдрөөс хэтэрч болохгүй. НТОЗШША нь онцгой тохиолдолд хариу өгөх хугацааг сунгахыг НААХЗА-ны зүгээс тавьж болно гэдгийн хүлээн зөвшөөрнө.
3. НААХЗА-ны ажилтанд НТОЗШША-ны явуулж буй шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэдээлэл байвал НТОЗШША-д байгаа мэдээллээр зөвлөгөө өгөхийг НААХЗА хүлээн зөвшөөрнө.
4. Шинжлэн шалгах ажлын явцад аюулгүй ажиллагааг хангах үүднээс НТОЗШША-аас ИНЕГ-т яаралтай арга хэмжээ авах зөвлөмж өгөхийг НААХЗА хүлээн зөвшөөрнө.

#### **Зургаа. Шинжлэн шалгах ажиллагаанд оролцох.**

1.1

1. НААХЗА нь НТОЗШША-аас хийж буй осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд оролцож болно.
2. Шинжлэн шалгах ажиллагаанд оролцогч НААХЗА-ны ажилтныг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох түвшинд нь эрх, үүргийг нь танилцуулсан гэрээнд гарын үсэг зурахыг шаардана.
3. НААХЗА-ны ажилтан НТОЗШША -ны шинжлэн шалгах ажиллагаанд оролцохдоо ахлах шинжээчид захирагдана.

4. Ахлах шинжээч шинжлэн шалгах ажиллагааг ур дунтэй дуусгах боломжийг бий болгохын тулд НААХЗА-ны ажилтан нь бүх нотлох баримттай харьцах эрх эдлэнэ.
5. НТОЗШША-ын шинжээч нарын мэргэшлийн ур чадварыг хадгалах үүднээс НААХЗА-ны үзлэг шалгалтад оролцуулах асуудлаар НТОЗШША ба НААХЗА-ны дарга нар харилцан тохиролцож болно.
6. Хэрэв НТОЗШША-ны шинжээчийг НААХЗА-ны үзлэг шалгалтад оролцуулвал тэрээр НААХЗА-ны байцаагчаас өгсөн хууль ёсны аливаа удирдамжийг дагаж мөрдөх ёстай.

#### Долоо. Осол, зөрчлийн тайлан.

1. Осол, ноцтой зөрчил, зөрчлийн тайланг Зам, Тээвэр, Аялал жуулчлалын Сайдын 2005 оны 3-р сарын 24-ны өдрийн 51 тоот тушаалаар батлагдсан “ Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 6-р зүйлийн дагуу гүйцэтгэнэ.

#### Найм. Аюулгүй ажиллагааны арга хэмжээ.

1. НТОЗШША-ны хийж байгаа шинжлэн шалгах ажиллагааны үеэр илэрсэн аюулгүй ажиллагааны зөрчил, дутагдлуудыг зассан буюу засах арга хэмжээ авч эхэлсэн НААХЗА-ны үйлдэлийн талаар шинжлэн шалгах үйл ажиллагааны тайландаа тодорхой хэмжээгээр тусгана. НТОЗШША нь аюулгүйн зөвлөмж хүлээлгүйгээр хийгдсэн аливаа үйлдлийг талархан хүлээн авна. Үүний тулд осол, зөрчлийн урьдчилсан тайланг НААХЗА-д танилцуулж эцсийн тайлан гарахын өмнө НААХЗА-аас аюулгүй ажиллагааны талаар урьдчилсан тайланд дурьдагдсан зөрчил, дутагдлуудыг зассан буюу засах арга хэмжээ авч эхэлсэн тухайгаа мэдэгдэнэ.
2. НТОЗШША нь осол, зөрчлийн шинжилгээ, судалгааны эхэн, явц эсвэл төгсгөлд ИНЕГ-т албан ёсны зөвлөмж гаргаж өгнө. Завлөмж боловсруулахын өмнө НТОЗШША нь ИНЕГ-тай зөвлөлдөж болох бөгөөд зөвлөмжид НТОЗШША – ны хүсэж буй шаардлагатай ур дүнг боломжийн хирээр тогтоож өгнө.
3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж гарснаас хойш 60 хоногийн дотор НТОЗШША -д бичгээр хариу өгөхийг ИНЕГ зөвшөөрнө. Бичгээр үйлдсэн хариултад зөвлөмж тус бүрийг хүлээж авсан, хэсэгчлэн хүлээж авсан эсхүл хүлээж авахаас татгалзсан талаар тодорхой мэдэгдсэн байна. Түүнчлэн бичгээр үйлдсэн хариулт нь зөвлөмжүүд, эсхүл тэдгээрийн аль нэг хэсгийг хэрэгжүүлэхэд мөрдөгдөх хуваарь болон горимын тухай дэлгэрэнгүй мэдээлэл; эсхүл аливаа зөвлөмж, эсхүл түүний аль нэг хэсгийг биелүүлэхгүй байх тухай шийдвэрийн бүрэн гүйцэд тайлбар болон санал болгож буй өөр ямар нэгэн ажиллагааны тухай заалтыг бас агуулж болно.
4. НТОЗШША нь өөрийн аль нэгэн зөвлөмжийг хүлээн авахыг ИНЕГ-т албадан тулгах эрхгүй.
5. Эцсийн тайлангийн төсөлд агуулагдсан зөвлөмжүүдэд ИНЕГ албан ёсны хариулт өгөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд цаг хугацааны боломжтой болон зохих орон зай нь байгаа үед хариултуудыг эцсийн тайланд оруулна.
6. Аль нэг зөвлөмжийн хэрэгжүүлэлт удааширсан тохиолдолд ИНЕГ нь талуудын харилцан тохирсон тодорхой хугацаа тутамд гарч буй ахиц дэвшилийн талаар НТОЗШША-д мэдээлнэ.

### Ec. Албан ёсны харилцаа

1. НТОЗШША-ны Дарга болон ИНЕГ-ын дарга, түүний тэргүүн дэд дарга нар харилцан сонирхсон асуудлаар бие биетэйгээ хэзээ ч харилцаж болно.
2. Энэхүү Харилцан ойлголцлын меморандумаар хүлээсэн үүргүүдтэй холбогдуулан НТОЗШША нь бүх мэдэгдэл, албан захидаа ИНЕГ-ын дарга, НААХЗА-ны даргад илгээнэ. ИНЕГ нь өөрийн албан захидаа НТОЗШША-ны даргад илгээнэ.
3. Хамтын ажиллагаа болон харилцан ойлголцлоо дэмжих үүднээс ИНЕГ болон НТОЗШША-ын ажилтнууд өдөр тутмын асуудлаар өөрсдийн түвшинд санал солилцохыг дэмжинэ. Гэхдээ ярилцах сэдэв нь НТОЗШША-ны осол, зөрчлийн тайланда ИНЕГ-ын байр суурийг илэрхийлэхээс бусад асуудал байх шугмыг аль аль нь баримтална.
4. НТОЗШША-аас гаргасан осол, зөрчлийн тайлан, өгөгдсөн зөвлөмжийн асуудлаарх байр суурийг зөвхөн ИНЕГ-ын дарга, НААХЗА-ны дарга илэрхийлнэ.
5. ИНЕГ-ын НААХЗА-ны дарга, НТОЗШША-ны дарга буюу тэдгээрийн томилсон төлөөлөгчид дараах асуудлуудыг хэлэлцэхийн тулд наад зах нь улирал тутам уулзах хэрэгтэй:


- хийгдэж байгаа үйл ажиллагаанууд үр ашигтай бөгөөд хамтын хүчин чармайлтаар хэрэгжиж байгааг баталгаажуулах
- ИНЕГ болон НТОЗШША-ны хооронд шийдвэрлэгдээгүй байгаа асуудлуудыг үргэлжлүүлэн хэлэлцэх
- стратегийн асуудлуудыг хэлэлцэх
- харилцан сонирхсон асуудлуудаа хэлэлцэх.

6. Энэхүү Харилцан ойлголцлын меморандумын аль нэг заалттай холбогдон аливаа үл тохиролцсон байдал эсхүл маргаан гарсан тохиолдолд энэ талаар НТОЗШША-ны дарга болон НААХЗА-ны дарга нар авч хэлэлцэнэ.

### Арав. Меморандумын хүчинтэй байх хугацаа ба түүнд оруулах өөрчлөлт.

1. Энэхүү меморандумд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
2. Энэхүү меморандумд өөрчлөлт оруулах асуудлыг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

НААХЗА-ны дарга



Ц.Бат

НТОЗШША-ны дарга



С.Хүрэлбаатар